

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ХАНДСҮРЭН

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

"АЛТАН ТУР" ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Б.АЛТМАА

**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ ХЭРЭГЖИЖ
БУЙ "ТҮМЭН ХААН РЕСОРТ АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР"
ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2703181

ХЯНАСАН:

ХБӨБЗГ-ИЙН ШИНЖЭЭЧ

БОЛОВСРУУЛСАН:

"АЛТАН ТУР" ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

A handwritten signature in black ink, appearing to be "O. AZZAYA".

О. АЗЗАЯА

2024 он

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	8
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	11
4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
6.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ..	18
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
9.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	21
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	24

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд.....	3
Хүснэгт 2. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа	13
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	17
Хүснэгт 5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	19
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	20
Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	21
Хүснэгт 8. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.	23
Хүснэгт 9. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө	24

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн байршлын зураг.....	3
Зураг 2. Ерөнхий төлөвлөлт	4
Зураг 3. Гэрийн хүчин чадал.....	4
Зураг 4. Хурлын заал	5
Зураг 5. Ресторан, лаунж.....	5
Зураг 6. Төслийн гаднах талбай.....	6
Зураг 7. Цахилгаан хангамж.....	6
Зураг 8. Худгийн байршил	7

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


Төслийн нэр: “Түмэн хаан” ресорт аялал жуулчлалын бааз

Төсөл хэрэгжүүлэгч: “Алтан тур” ХХК /улсын бүртгэлийн дугаар: 9011098031, регистрийн дугаар: 2703181, албан ёсны хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 1-р хороо, 12-р хороолол, 47-7 тоот, утас: 99086928/

Төслийн байршил: Улаанбаатар хот, Налайх дүүрэг, 6-р хорооны нутагт байрлана.

Хүснэгт 1. Төслийн талбайн эргэлтийн цэгийн солбилцолууд

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	107	23	18.830	47	58	54.240
2	107	23	27.800	47	58	54.300
3	107	23	32.431	47	58	52.797
4	107	23	38.849	47	58	49.683
5	107	23	34.365	47	58	46.510
6	107	23	29.223	47	58	48.706
7	107	23	18.140	47	58	52.720




Зураг 1. Төслийн байршлын зураг

Төслийн хүчин чадал

Барилгын ерөнхий үзүүлэлт: Тус бааз нь төслийн хүрээнд:

- Задгай кино театр
- Авто зогсоол
- Тайз
- Спорт талбай
- Автомашинны граж
- Шорлогийн талбай
- А,В,С блок
- Дугуйн амралтын талбай зэргийг нэмж байгуулахаар төлөвлөсөн байна.



Зураг 2. Ерөнхий төлөвлөлт

“Түмэн Хаан” бааз нь ерөнхий төлөвлөгөөний дагуу 2022 оны 9 сарын 12-ны байдлаар нийт 32 ширхэг гэрийг амралт үйлчилгээний зориулалтаар ашиглаж байна.

- 2 ортой 1 ширхэг гэр
- 3 ортой 10 гэр
- 4 ортой 19 гэр
- 5 ортой 2 гэр
- 10 ортой 1 гэр



Зураг 3. Гэрийн хүчин чадал

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутагт байрлах “Түмэн хаан ресорт аялал жуулчлалын бааз”-ын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

“Түмэн Хаан” бааз нь 50 хүний багтаамжтай нэг хурлын заалтай.



Зураг 4. Хурлын заал

“Түмэн Хаан” бааз нь нэг дор 84 хүнийг хүлээн авах хүчин чадалтай ресторантай, 4 хүний 6 ширээтэй жижиг лаунжтай.



Зураг 5. Ресторан, лаунж

Гадна талбайн хувьд тус бааз нь тоглоомын талбайн болон 2 ширхэг саравчтай.



Зураг 6. Төслийн гаднах талбай

Төсөл хэрэгжих талбайн дэд бүтэц

Цахилгаан хангамж: “Алтан тур” ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны Горхи-Тэрэлжийн нутагт орших “Түмэн хаан ресорт” төслийн талбай нь цахилгаан эрчим хүчний хэрэглээг төвийн эрчим хүчний шугам сүлжээнээс татан авч, бууруулах трансформатороор дамжуулан авч хангадаг.



Зураг 7. Цахилгаан хангамж

Усан хангамж: Тус төслийн талбай нь усны хэрэгцээг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг. Улаанбаатар хотын Эрдэнэдрилинг компаний супер 6000 маркийн станкоор 70м гүнтэй, 1.2л/сек ундарга бүхий худгийн цооногийг 2007 оны 11 сарын 26 батлуулсан байна.




Зураг 8. Худгийн байршил

Дулаан хангамж: Тус төслийн талбай нь халаалтын хувьд цахилгаан халаагч хэрэгслийг ашиглаж байсан.

Харилцаа холбоо: Тус талбай нь харилцаа холбооны хувьд богино долгионы радио станц болон үүрэн телефоны утасны сүлжээ, мөн интернетийн сүлжээгээр бүрэн хангагдсан. Сансрын VSAT антенныг ашиглан телевизийн сувгуудыг хүлээн авах боломжтой.

Зам харилцаа:



Зураг 9. Зам харилцаа төлөвлөлтийн зураг

Тус бааз нь 1529м² хүчин чадалтай 318м урттай авто зам, 2619м² хүчин чадалтай 1870м явган хүний зам, 742м² хүчин чадалтай 125м урттай авто зогсоол, 1543 м² хүчин чадалтай 772м урттай дугуй зам хийхээр төлөвлөсөн.

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ТҮҮНИЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл: Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар нь улаанбаатар хотоос зүүн тийш 60 километр оршдог. ГТБЦГ-т Төв аймгийн Эрдэнэ сум, Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрийн нийт 293168.0 га талбай хамрагдах ба Хэнтийн нурууны зүүн өмнөд хэсэгт байрлана.

Тус БЦГ-ын хамгийн хойд хэсэг нь Хан Хэнтийн ДЦГ болон ГТБЦГ-ын хилийн заагт оршдог. Гэл уул (2550.8х.ө. 480251332, з.у. 1070381348), өмнөд цэг нь Гандан уулын ар, Туул голын урд эрэгт орших ба хойноосоо урагш 77км үргэлжилнэ. Баруун захын цэг нь Дархитын даваанаас баруун хойд зүгт орших 2045.6 тоот өндөрлөг (х.ө 480121465), зүүн захын цэг нь Юдэгийн даваа (1985.0, х.ө 480171747, з.у 10806169) ба баруунаас зүүн тийш 70км үргэлжилнэ.

Цогцолборт газрын хамгийн өндөр цэг нь Алтан-Өлгий уул (2645.7), хамгийн нам цэг нь Туул голын Бүдүүн чулууны гарам (1376.0) юм.

Ландшафт: Хэнтийн районы ландшафтын үндсэн хэв шинж бөгөөд гадаргын ихэнх хэсэгт тархсан байдаг. Тайгын ландшафт нь Хангай, Хөвсгөлийн уулын тайгын ландшафтыг бодвол өвөрмөц.

Уул хээрийн ландшафт: Төслийн талбайн урд захаар шинэс хусан ой бүхий уул хээрийн ландшафт голын эрэг рүү түрж орсон нам уулсаар тархсан. Төслийн талбайн ойр орчим гуу жалга багагүй байсан. Хад цохио цөөнгүй харин асга ховор.

Намагт нугын ландшафт: Намагт нугын ландшафт голуудын хөндий дагуу түүний өргөсөн хэсэг болон бэлчир орчмын тэгшивтэр гадаргад үүсэж тогтворжсон байдаг.

Төслийн талбай нь Хэнтийн нурууны байгалийн ойт хээрийн бүсэд хамаарч байна.

Уур амьсгал: Горхи тэрэлжийн БЦГ нь эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгалын үзүүлэлтүүд нь тэгш химийн хуваарилалттай, чийглэг зэврүүн зун, хахир өвөлтэй уур амьсгалын мужид багтах бөгөөд уур амьсгалын нөхцөлийн хувьд чийгийн хангамж 1- ээс их, нэмэх температурын нийлбэр буюу дулаан хангамж нь 15000С-ээс их нутаг болно.

ГТБЦГ нь хамгийн өндөр чийгшилтэй нутагт тооцогдоно. Хилд унах хур тунадасны нийлбэр олон жилийн дунджаар 350 орчим мм байхаас, 95-97 хувь нь дулааны улиралд унах ба олон жилийн нийлбэрийн дундаж нь 100-120мм. 2021 оны байдлаар Тэрэлж өртөө орчим 345,7 мм хур тунадас унасан байна. үүнээс харахад төслийн талбай орчим хур тунадас харьцангуй сайн ордог бүс нутагт хамаарна. 2021 оны байдлаар нийт орсон хур тунадасны 87,9% нь 5-9-р сарын хооронд бороо хэлбэрээр орсон байна. төслийн талбай орчим 2021 оны байдлаар хамгийн их хур тунадас орсон сар нь 7-р сар 94 мм бол хамгийн бага хур тунадас унасан сар нь 1-р сард 2,1 мм байна.

Харьцангуй чийгшил нь тухайн агаар чийгээр хангахад шаардагдах чийгийн хэмжээний хэдэн хувийг эзэлж байгааг илэрхийлнэ. Энэ нь тухайн газар нутгийн уур амьсгалын чийглэг буюу хуурай болохын шинж төлөвийг илэрхийлэх маш чухал үзүүлэлт бөгөөд түүнийг уур амьсгалын судалгаанд өргөн хэрэглэдэг. Харьцангуй чийгшил нь 7,12,1 саруудад их байдаг нь дулааны улирлын хур тунадас их ордогтой, өвөл манай оронд хүйтрэхэд агаарын чийг агуулах чадвар багасдагаар тайлбарлагдана. Жилийн дундаж харьцангуй чийгшил 70-75% хүрч хамгийн хуурай хаврын улиралд 45-55% байна. Энэ бүс нутагт хуурай өдөр 15-20 өдөр тохиолдож байхад 30-40 өдөр нь 80%-иас дээш чийгтэй байдаг. Зарим жилд өдрийн харьцангуй чийгшил 10%-иас доош орох тохиолдол гарч байсан байна.

Геологийн тогтоц: Хэнтий нуруу нь геологийн тогтцын хувьд нилээд цомхон боловч өвөрмөц дүрх төрхтэй. Хэнтий нуруунд анх төрмөл, эрт төрмөл, дунд төрмөлийн эриний настай гүний болон тунамал чулуулаг тархсан байна. Эрт төрмөлийн чулуун нүүрсний галавын нүүрст бх нүүрстөрөгчит шаварлаг занар, Туул, Заан голуудын эхэн сав газраар, девоны ангилагдуугүй чулуулаг, цахиурлаг занар, хас нүүрст ба нүүрстөрөгчит шаварлаг занар зэрэг чулуулаг Өвөр Минж, Туулын эх, Тэрэлжийн сав газраар тархсан байна. Хөрс үүсгэгч дөрөвдөгчийн аллюви, эллюви, делюви, пролюви, мөсдлийн хурдсууд Хэнтийд өргөн тархсан байдаг. Неоген, дөрөвдөгчийн хурдсууд уулс хоорондын хотгор, хонхор, голуудын хөндийг дүүргэсэн байдгаас гадна төвийн өндөр уулсын хавьд зарим хэсэгтээ аллювийн хурдас, дөрөвдөгчийн өмнөх үеийн хурдас алаг цоог тархана.

Гадаргын ус: Төслийн талбай орчим нь гадаргын усны олон улсын ай савын ангиллаар манай орны хамгийн их гол мөрөнтэй гэгдэх Хойд мөсөн далайн ай савд багтана. Дотоодын гол мөрнүүдийн ай савын хувьд Чингэлтэйн уулсын өвөр хажуугаас Богдхан уул хүртэлх нутаг Туул голын ай савд багтах бол, Чингэлтэй уулын ар хажуугаас хойш орших нутаг нь Хараа голын ай савд багтана. Томоохон голууд нь Туул гол, түүний цутгал голууд болох Улиастайн гол, Сэлбийн гол, Гачууртын гол, Тэрэлжийн гол, Хуйн гол зэрэг болно. Мөн энэ бүс нутаг нь өндөр уул, ой ихтэй уулсын амнуудаар олон жижиг гол горхинууд улирлын шинжтэй урсах болон, бороо хур элбэгтэй жилүүдэд байнга урсацтай болох нь элбэг. Энэ бүсэд голын сүлжээний нягтшил 0,1-0,5 км/км² байгаа нь манай орны нийт нутгийн дунджаас дээгүүр үзүүлэлт юм. Гадаргын усны урсцын хэмжээ нь 60-90 мм байна. Гадаргын уулархаг байдлаас шалтгаалан томоохон тогтоол ус, нуур тогтоогүй байна.

Хөрсөн бүрхэвч: Төслийн талбай орчмын бүс нутаг нь газрын гадаргын хувьд Налайх орчмын хаяа уулсын системд хамаарагдах нам уулсын системд байрлана. Тус судалгааны талбай нь хөрс газарзүйн мужлалаар хөрс-био уур амьсгалын их мужийн холимог бүсчлэл бүхий Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутаг хэв шинжийн Хэнтийн захын буюу 39-р тойрогт багтана. Уулын нугын болон уулын ойн ширэгт хөрс, ойн доод хил орчмоор уулын болон

нугат хар хүрэн хөрс, уулсын бэл хажуу хэсгээр хар хүрэн, голын хөвөө орчмын өндөрлөг, төв татмын өндөрлөг газраар доод аллювийн ширэгт хөрс зонхилно.

Амьтны аймаг: Амьтны аймгийн хувьд Налайх хотын нутаг дэвсгэрийн төв болон баруун хэсэгт амьтны аймгийн төрөл зүйл аль хэдийн байгалийн нутагшил, шилжих хөдөлгөөн нь бүрэн алдагдаж зөвхөн хот сууринд амьдардаг цөөн тооны хөхтөн, шувуу зэрэг амьтад байгаа болно. Тухайлбал шувуудын дотроос тоо толгойн хувьд оронгийн (*P.domesticus*) ба хээрийн (*P.montanus*) бор шувуу, хөхвөр тагтаа (*C.livia*), Сохор элээ (*Milvus migrans*), Шаазгай (*Pica pica*), Улаан хошуут (*Pyrrhocorax pyrrhocorax*), Хар хэрээ (*Corvus corone*), Хон хэрээ (*Corvus corax*) арай олон үзэгдэнэ. Хөхтний дотроос дагуур зурам, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, гэрийн хулгана нутагшиж байна. Шавжийн ангиас ихэвчлэн төрөл бүрийн цохын овог тааралдана.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл:

- Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт хий
- Тоос, тоосонцор нь тунадасжин бууж хөрс, гүний усанд орж тархах, бохирдуулах
- Тоосжилт ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл:

- Тээврийн хөдөлгөөнөөс хөрсний эвдрэл үүсгэх
- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга эвдэгдэх
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Тоос хөрсөнд хуримтлагдаж бохирдол үүсэх

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл:

- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор ургамлан нөмрөг талхлагдах
- Тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх
- Барилгын ажлын үед үүсэх барилгын хог хаягдалд ургамлан нөмрөг талхлагдах

Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагаанд өртсөн талбайн ургамлан нөмрөг устгах бөгөөд үүнийг даган бичил амьтад ч мөн амьдрах орчноосоо дайжна.
- Дуу чимээ, тоосны бохирдол, амьтны нүх, үүрэнд шууд нөлөөлснөөр амьдрах орчинд сөргөөр нөлөөлнө.
- Ургамлан нөмрөгт төслийн үйл ажиллагааны явцад ялгарсан, асгарсан бохирдуулагч материалууд хуримтлагдсанаас өвсөн тэжээлтэн амьтад хордох
- Төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаар амьтдын амьдрах орчин бохирдох, зарим зүйл амьтан хордох магадлалтай.
- Амьтдын амьдрах орчин хуваагдах

Дуу чимээний үзүүлэх нөлөөлөл:

- Төслийн үйл ажиллагаа эхэлснээр үүсэх дуу чимээ нь ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх
- Нутгийн оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах
- Амьтдад ойр орчмоос дайжих

4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар батлагдсан 2019 оны А/168 тоот “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг үндэслэл болголоо.

Байгаль орчинд бага сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа явуулахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай.

- Байгаль орчны бохирдолоос сэргийлэх, байгаль орчинд учрах нөлөөллийг хамгийн бага байлгахад анхаарах
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, бусад холбогдох хууль, дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллах
- Байгаль орчныг хамгаалах, ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс ажилчдад сургалт зохион байгуулах
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу мониторинг, хяналт-шинжилгээ хийлгэх
- Компанийн ажилтнууд, нутгийн иргэд болон сонирхогч талуудад байгаль орчны асуудлыг нээлттэй, шударга, ил тод байлгах

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд 2610000 төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах аргагүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутагт байрлах “Түмэн хаан ресорт аялал жуулчлалын бааз”-ын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 2. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал /мян.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний төлөвлөгөө	-
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	1.000.0
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	400.0
6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	750.0
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	160.0
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	300.0
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал		2.610.000

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Алтан тур” ХХК-ийн “Түмэн хаан ресорт аялал жуулчлалын бааз”-ын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг нэгтгэж доорх хүснэгтэд тусгалаа.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт, стандарт
1. АГААРЫН ЧАНАР									
1	Горхи-Тэрэлжийн БЦГ орчмын авто тээврийн хөдөлгөөн ихэссэнээс агаар дахь тоосны хэмжээ CO, SO ₂ , NO ₂ ихсэж, орчны хүчилтөрөгчийн /O ₂ / хэмжээ багасах, үйлчлүүлэгч иргэд, аялагчдын автомашины шатах тослох материалын ууршилт, утаа тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчин бохирдуулах, -	Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах болон салхинаас хамгаалах зорилгоор мод бут тарих	Төслийн талбай	-	-	-	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд тусгасан	2025 онд	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль; Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008 Бензин хөдөлгүүртэй авто машин- Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Дизель хөдөлгүүртэй авто машин- Утааны тортогжилтын
2	Горхи-Тэрэлжийн БЦГ орчмын авто тээврийн хөдөлгөөн ихэссэнээс агаар дахь тоосны хэмжээ CO, SO ₂ , NO ₂ ихсэж, орчны хүчилтөрөгчийн /O ₂ / хэмжээ багасах, үйлчлүүлэгч иргэд, аялагчдын автомашины шатах тослох материалын ууршилт, утаа тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчин бохирдуулах, -	Төслийн талбай дахь гадна, дотор байрлуулсан бүх хогийн савыг өдөр бүр суллан цэвэрлэж байх	Төслийн явцад	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжих хугацаанд	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль; Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2008 Бензин хөдөлгүүртэй авто машин- Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5013:2009 Дизель хөдөлгүүртэй авто машин- Утааны тортогжилтын

									зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
2. ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ									
3	Автомашин хөдөлгөөн зэргээс хөрс элэгдэл, эвдрэл үүсэхээс гадна	Төсөл хэрэгжих талбайн ургамал талхлагдсан газруудад олон наст ургамлын үр тарьж ургамалжуулах	Төслийн талбай	-	-	-	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн арга хэмжээнд тусгасан	2025 онд	Газрын тухай хуулийн 50-р зүйл 50.1.1 дэх заалт. MNS 5917:2008 MNS 5918:2023
4	хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсч болзошгүй.	Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	Төсөл хэрэгжих хугацаанд	Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
5		Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх	Төслийн талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	
3. ГАДАРГЫН БА ГАЗРЫН ДООРХ УСНЫ НӨӨЦ									
6	Усны нөөц багасах, түвшин буурах	Усыг ариг гамтай ашиглах	Төслийн явцад	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998.

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутагт байрлах “Түмэн хаан ресорт аялал жуулчлалын бааз”-ын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

									”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982.
4. АМЬТНЫ АЙМАГ									
7	Авто машины зогсоол, засварын цех	Төв замаас амралт хүртэл зөвхөн нэг замтай байлгах, үүний тулд тэмдэгжүүлэх	Авто зогсоолын хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардлаар	2025 онд	Хог хаягдлын тухай хууль 2017 он Амьтны тухай хууль 2012 он
8	Хог хаягдлыг амьтанд хоргүйгээр шийдвэрлэх	Хог хаягдалыг ил задгай хаяж хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтад үржих, хордох нөхцөл бүрдүүлэхгүй байх	Төслийн хог хаягдлын хүрээнд	-	-	-	Хог хаягдлын менежментийн зардалд	2025 онд	
9	Амьтанд гэмтэл учруулах, тоо толгой хорогдох	Ажилчдыг байгаль орчныг хамгаалах, ан амьтдад хохирол учруулахгүй байх талаар сургалт зохион байгуулах	Төсөл хэрэгжих хугацаанд	-	-	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан	2025 онд	
Нийт мян.төг				-					

6.ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
1	Төслийн талбайд ногоон байгууламжтай болсоноор агаарын тоосжилт буурах зорилттой /Тэрбум мод төслийг хэрэгжүүлэх/	Аялал жуулчлалын газрын талбайд ургамал талхлагдсан газруудад олон наст ургамлын үр тарьж ургамалжуулах	-	-	-	400.0	2025 онд	MNS 5918:2023 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
2		Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд 50 ширхэг мод тарих /Гацуур мод болон шар хуайс, голт бор зэрэг цэцэглэдэг бут сөөг зэргээс сонгон тариалах/	ш	50		600.0	2025 онд	
Нийт дүн, сая.төг						1.000.0		

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2025 оны БОМТ-д нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй байна. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжыг мөрдөн ажиллах шаардлагатай.

9.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Цаг агаарын үзэгдэл, ажилчдын хариуцлагагүй байдлаас	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Төсөл хэрэгжих үед	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2025 онд	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	шалтгаалан осол гарах	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	Төсөл хэрэгжих үед		Үйл ажиллагааны зардлаар		2025 онд	
2		Ажилтан албан хаагчдад сургалт зохион байгуулах, аюулгүй ажиллагааны талаарх мэдээллийг өгч байх, самбартай байх	Төсөл хэрэгжих үед	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан		2025 онд	
3		Болзошгүй аюул ослын үед ашиглах багаж хэрэгсэл холбооны хэрэгсэлтэй болох / Гал унтраах багаж хэрэгсэл, элс, шороо, хүрз цэвэрлэгээний бодис, холбооны хэрэгсэл гэх мэт /	Төслийн ажилчдын хүрээнд	-	300.0	300.0	2025 онд	
4	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд 1 удаа зохион байгуулах	Төсөл хэрэгжих үед	-	100.0	100.0	2025 онд	
			Нийт зардал (мян.төг)		400.0			

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Ахуйн хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хаягдалын цэгийг стандартын шаардлагад нийцүүлэн битүүмжлэл сайтай хийх, хаягдлыг богино хугацаанд нутаг дэвсгэрээс зөвшөөрөгдсөн цэг рүү зайлуулах	Төслийн талбайн бүх барилга байгууламжуудад	-	250.0		250.0	2025 он	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.1.энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;
2		Хог хаягдлын түр хадгалах цэгийг ангилан ялгах, битүү тагтай, хог хаягдал салхиар хийсч тарахааргүй байхаар сайжруулах	Төслийн талбайд	-	200.0		200.0	2025 он	
3	Шингэн	Гал тогоо, хог хаягдлын цэг, 00-ийн ариутгал халдваргүйжүүлэлт	Төслийн талбайд	-	300.0	-	300.0	Сард 1 удаа	
		Нийт мян.төг	750.0						

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Хөрсний бохирдол								
1	Хөрсний химийн шинж чанар, механик бүрэлдэхүүн	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 1 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	35.0	35.0	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. (2008). Монгол улсын стандарт - MNS 5850:2008. Улаанбаатар.
2	Хүнд металлын агууламж	Хөрс түлш, шатах тослох материалаар бохирдох	Төслийн талбайд 1 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	35.0	35.0	Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох арга. (1991). Монгол улсын стандарт - MNS 3310:1991. Улаанбаатар.
3	Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ хийлгэх	Төслийн талбайн хог хаягдал, шингэн хог хаягдалаар бохирдох	Төслийн талбайд 1 цэг сонгох	2025 он	Жилд 1 удаа	40.0	40.0	Хөрсний чанар. Хөрсөнд эрүүлзүйн нян судлалын шинжилгээ хийх арга. (2012) MNS 6341:2012. Улаанбаатар. Хөрс. Гэдэсний бүлгийн нян ,гэдэсний бүлгийн халуун даадаг нян болон байж болох E.Coli-г илрүүлэх арга. (2004) MNS 5367:2004. УлаанбаатарMNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2. Усны хяналт шинжилгээ								

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутагт байрлах “Түмэн хаан ресорт аялал жуулчлалын бааз”-ын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

4	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбайд	Унд ахуйн ус хангаж буй гүний худгаас	2025 он	Жилд 1 удаа	50.0	50.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
Нийт зардал мян.төг						160.0		

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. БОМТ-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг мян.төг	Зардал мян.төг	Хугацаа
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх шинэчлэн засварлах	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод зохион байгуулалтаар		2025 он
2	Өрөө бүр хог хаягдлын ангилан ялгах боломжтой хогийн сав байршуулах	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод зохион байгуулалтаар		2025 он
3	Осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, зохион байгуулах	Төсөл хэрэгжих хугацаанд		100.0	2025 он
4	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ-т хүргэн өгч байх	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод зохион байгуулалтаар		Жил бүрийн 11 сард
5	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө	Төсөл хэрэгжих хугацаанд	Дотоод төлөвлөлтөөр		2025 он
6	Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	Төсөл хэрэгжих хугацаанд		200.0	2025 он
Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал				300.0 мян.төг	

13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн дүүргийн иргэдийн хуралд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийж байх шаардлагатай болно.

Хүснэгт 9. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газарт танилцуулах	Цахим болон бичгээр	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хянуулах	2025.он	Дотоор төлөвлөлтөөр	“Алтан тур” ХХК-ын байгаль орчны мэргэжилтэн	Горхи тэрэлжийн байгалийн цогцолбор газарт танилцуулах
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Цахимаар					Цахимаар
Нийт				-		